



## ӨСВӨР ҮЕИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

### МОНГОЛЫН ХОЛИМОГ ТУЛААНЫ ХОЛБОО (МХТХ)

#### 1. Хөтөлбөрийн зорилго

- **Зорилго:** Монголын Холимог Тулааны Холбооны (МХТХ) Өсвөр үеийн Хөгжлийн Хөтөлбөрийн гол зорилго нь холимог тулааны залуу авьяастнуудыг илрүүлэн хөгжүүлж, өндөр түвшний чадварлаг тамирчдыг тасралтгүй бэлтгэн гаргахад оршино. Энэхүү хөтөлбөр нь тамирчдын техникийн ур чадварыг сайжруулахын зэрэгцээ бие бялдрын чийрэгжилт, сахилга бат, хүндлэл, тэсвэр тэвчээр, хариуцлага зэрэг холимог тулааны спортын үнэт зүйлсийг тэдэнд ухамсарлуулан суулгаж, хүүхэд залуусыг спортоос гадна амьдралдаа үүрэг хариуцлагатай, ухамсартай, зөв нэгэн болж хөгжиж төлөвшихөд туслах зорилготой юм.

#### 2. Зорилтот бүлэг

- **Насны бүлэг:** 10–аас 18 нас
- **Тавигдах шалгуур:** Орон нутгийн тэмцээнүүд, сургууль болон олон нийтийн арга хэмжээнүүдээс холимог тулааны авьяаслаг залуу тамирчдыг нээн илрүүлэхийг хөтөлбөр зорино. 10-аас дээш насны хүүхдүүдээс бие бялдрын чийрэгжилт, сахилга бат, хүмүүжил төлөвшил, сурах хүсэл эрмэлзэл зэрэг чанаруудыг харгалзан үзэж сонгон шалгаруултыг хийнэ. Спортын өмнөх туршлагаас нь үл хамааран бүх хүүхдэд холимог тулааны спортоор хичээллэж, ур чадвараа сайжруулах боломж ингэснээр олдох юм.

#### 3. Гол бүрэлдэхүүн хэсгүүд:

- **Авьяастныг олж илрүүлэх болон элсүүлэх:**

Сургууль, спортын клуб, орон нутгийн байгууллагуудтай хамтран холимог тулааны спортод авьяастай, дур сонирхолтой залуу тамирчдыг хайн олж илрүүлэх. Авьяас чадвартай залуу тамирчдыг сонгон шалгаруулах арга хэмжээ, сорилго тэмцээнүүдийг аймаг орон нутгуудад тогтмол зохион байгуулах.

- **Сургалт болон ур чадварын хөгжил:**

Бүс болон аймгуудын томоохон хотуудад залуу тамирчдад зориулсан тусгай бэлтгэлийн төвүүдийг үүсгэн байгуулж, туршлагатай холимог тулааны дасгалжуулагчдаар мэргэжлийн сургалт орох.

Холимог тулааны суурь ур чадварууд, бие бялдрын бэлтгэлжилт, сэтгэл зүй, сахилга батыг сайжруулахад чиглэсэн тогтмол бэлтгэлийн бааз, цугларалтуудыг зохион байгуулах.

Босоо тулаан болон хэвтээ барилдаанд зориулсан мэргэшсэн сургалт явуулахын зэрэгцээ хувь хүн болон багт суурилсан тулааны стратегийг боловсруулах.

- **Өсвөрийн холимог тулааны хөтөлбөр:**

Холимог тулааны ирээдүйн авьяастнуудыг хөгжүүлж, бага наснаас нь туршлага суулгахын тулд өсвөр үеийн тэмцээнүүд болон бэлтгэлийн баазуудыг тогтмол зохион байгуулах.

- **Клубийн систем:**

- **Клуб суурьтай хөгжил:** Монгол орны аймгийн төвүүдэд шат дараатайгаар орон нутгийн холимог тулааны клуб үүсгэн байгуулах. Энэ нь үндэсний түвшинд бэлтгэл хийх боломжуудыг олгох бөгөөд клубийн системээр дамжуулан хөгжих тодорхой замыг тамирчдад бий болгоно. Клубийн систем нь залуу тамирчдыг хөгжүүлэхэд дараах үүргүүдийг гүйцэтгэнэ:
  - Шинээр эхэлж буй тамирчдад зориулсан анхан шатны холимог тулааны хөтөлбөр.
  - Ахисан түвшний тамирчдад зориулсан тусгай бэлтгэл.
  - Бүс болон аймгийн түвшний тэмцээн, арга хэмжээнүүд.
- **Клубийн тэмцээнүүд:** Залуу тамирчдын тэмцэж өрсөлдөх сэтгэл зүйг хурцалж, ур чадварыг сайжруулахын тулд клуб хоорондын тэмцээнүүдийг зохион байгуулах.
- **Клуб нэтворкинг:** Клуб хооронды хамтын ажиллагааг дэмжиж, хамтарсан бэлтгэл, цугларалт зэргээр дамжуулан тамирчдын ур чадвар, нийтэч нэгдмэл байдлыг сайжруулах.

- **ОУХТХ-ны Дасгалжуулагчийн сертификат: Түвшин 1:**

- Дасгалжуулагч нарт ОУХТХ-ны Дасгалжуулагчийн 1-р түвшний сертификат авах боломж нөхцлийг бүрдүүлэх. Ингэснээр Монгол дахь холимог тулааны дасгалжуулагчдын ур чадвар, мэдлэг боловсрол нэмэгдэж, өсвөр үеийн залуу тамирчдад ирэх сургалтын чанар сайжирна.

- **ОУХТХ-ны Өсвөрийн тамирчдын үнэлгээний систем**

ОУХТХ-ны Өсвөрийн тамирчдын үнэлгээний систем нь залуу тамирчдад хөгжлийнхөө ахиц дэвшлийг тогтмол хянах, дасгалжуулагчдаас байнгын үнэлгээ болон зөвлөгөө авах боломжийг олгоно. ОУХТХ-ны аппликейшнээр дамжуулан тамирчид өөрсдийн хөгжлийн үйл явцаа шууд хянах, сургалтын материалтай танилцах, багштайгаа харилцан ярилцаж байнгын зөвлөгөө авах боломжтой.

Үнэлгээний системийн гол онцлогууд:

- **Түвшингүүд:** Тамирчдын техникийн ур чадвар, тэмцээнд үзүүлсэн амжилт, бие бялдрын бэлэн байдлыг үндэслэн дараа дараагийн шат руу ахих эрх үүснэ.
- **ОУХТХ аппликейшн:** Аппликейшн нь тамирчдад үнэлгээний явцаа хянах, дасгалжуулагчаас зөвлөгөө авах, хөгжлийнхөө явцыг тасралтгүй үргэлжлүүлэх боломжийг олгоно.
- **Урам зориг ба үнэлгээ:** Түвшин ахих тусам тамирчид сертификат болон тэмдэг хүртэж, үүнээсээ урам зориг аван цаашид илүү хөгжиж сайжрах хүсэл эрмэлзэлтэй болно.
- **Топ түвшинд хүрэх зам:** Энэ систем нь тамирчдад орон нутгийн түвшний тэмцээнээс үндэсний болон олон улсын тэмцээнд шилжих тодорхой чиглэлийг санал болгоно.
- **Бүгдийг хамарсан, уян хатан:** Үнэлгээний систем нь холимог тулааны залуу тамирчдад өөрт тохирсон түвшнээс сургалтаа эхлэх боломжийг олгоно.

Энэ системийг МХТХ-ны Өсвөр үеийн хөгжлийн хөтөлбөрт нэгтгэснээр залуу тамирчдад дотоод болон олон улсад амжилттай өрсөлдөж, тууштай хөгжиж сайжрах нөхцлийг бүрдүүлж өгнө.

- **Өсвөрийн шигшээ баг:**
  - Олон улсын түвшинд өрсөлдөх өсвөрийн шигшээ багийг байгуулж, залуу тамирчдад өсөж хөгжих, насанд хүрэгчдийн тэмцээнд шилжих тодорхой замналыг бий болгоно.
- **Менторшип ба дасгалжуулалт:**
  - Залуу тамирчдыг туршлагатай менторууд эсвэл мэргэжлийн тулаанчидтай хослуульж, тэдэнд зөвлөгөө өгөх, урам зоригийг нь нэмэх.
  - Өсвөр үеийн тамирчдын хөгжлийн чиглэлээр мэргэшсэн дасгалжуулагчдын багийг бүрдүүлж, төрөл бүрийн насны ангилалд тохирсон сургалтын хөтөлбөрүүд боловсруулах.

#### 4. Боловсролын дэмжлэг:

- **Спортын шинжлэх ухааны боловсрол:** Хоол тэжээл, бэртлээс урьдчилан сэргийлэх, бие бялдрын чийрэгжилт, сэтгэл зүйн бэлтгэл гэсэн чиглэлүүдэд сургалт өгч, тамирчдад бүрэн гүйцэд хөгжих нөхцөл бүрдүүлэх.
- **Боловсролын интеграц:** Залуу тамирчдыг спортын замнал болон боловсролоо тэнцвэртэй хослуулахыг уриалж, уян хатан сургалтын хуваариар тэдэнд боловсролдаа анхаарахад туслах.
- **Цахим платформуудыг боловсролд ашиглах:**
  - **Вебсайт болон социал медиа:** МХТХ-ны вэбсайт болон социал медиаг ашиглан залуу тамирчдад ОУХТХ-ны дүрэм журам, аюулгүй байдал, допингийн эсрэг арга хэмжээ болон бусад чухал сэдвүүдийн талаар боловсрол олгох. Эдгээр платформууд нь холимог тулаантай холбоотой мэдээ мэдээлэл, сургалтын материал, боловсролын контентийг тамирчид, дасгалжуулагчид

болон олон нийгэд тогтмол шинэчилсэн байдлаар хүргэж чадахаараа давуу талтай.

## 5. Тэмцээн болон таниулга

- **Өсвөр үеийн тэмцээнүүд:**
  - Өсвөр үеийн холимог тулааны тэмцээнүүдийг тогтмол давтамжтай зохион байгуулж, залуу тамирчдад тэмцээний туршлага хуримтлуулж, ур чадвараа сайжруулах боломжийг олгох.
  - Өсвөр үеийн шилдэг тамирчдыг жагсаасан чансааны системийг бий болгож, өндөр түвшний тэмцээнүүдэд оролцох боломжийг бүрдүүлж, урам зоригийг нэмэгдүүлэх.
- **Олон улсын тэмцээнүүд:**
  - Шигшээ багийн гишүүн болсон залуу тамирчдад олон улсын түвшинд өрсөлдөх боломжийг олгож, туршлага хуримтлуулж, дэлхий дахинд танигдах боломжийг бүрдүүлэх.
  - Бусад орны өсвөр үеийн хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, нэгдсэн сургалтын хөтөлбөрүүд болон хамтарсан тэмцээнүүдийг зохион байгуулах.

## 6. Тамирчдын дэмжлэг ба хөгжил

- **Бие болон Сэтгэл зүйн эрүүл мэндийн дэмжлэг:**
  - Эрүүл мэндийн дэмжлэг, спортын сэтгэл зүйч, мэргэжлийн эмч нараас тусламж дэмжлэг, зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэх.
  - Бэртлээс урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх эмчилгээний талаар дэмжлэг үзүүлэх.
- **Тэтгэлэг болон Санхүүжилт:**
  - Өсвөрийн тамирчдад бэлтгэл сургуулилт, боловсрол мэдлэг, тэмцээн, арга хэмжээнд оролцоход хэрэгтэй зардалд туслах зорилгоор санхүүжилтийн арга замууд олох.

## 7. Урт хугацааны зорилго

- **Мэргэжлийн түвшин рүү шилжих:**
  - Ирээдүйтэй авьяаслаг тамирчдыг дотоод болон олон улсад өөрсдийгөө сорьж, таниулж, мэргэжлийн түвшинд шилжихэд нь туслах.
- **Өсвөрийн хөтөлбөрийн тогтвортой байдал:**
  - Тамирчдын хөгжилд шаардлагатай санхүүжилтийг хангах, урт хугацааны амжилтыг бататгах зорилгоор ивээн тэтгэгчид, сургуулиуд болон төрийн байгууллагуудтай тогтвортой түншлэлүүдийг байгуулах.
  - Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхийн тулд санал хүсэлтийг нээлттэй хүлээн авч, тамирчдын хөгжлийн хэрэгцээг харгалзсан сургалт, менторшип, дэмжлэгийн системийг боловсруулах.

## 8. Хөтөлбөрийн үнэлгээ ба шалгалт

- Зохион байгуулсан сургалтын хөтөлбөр, арга хэмжээ, тэмцээнүүд хэрхэн яаж тамирчдын хөгжилд үр нөлөө үзүүлснийг үнэлж цэгнэх зорилгоор жил бүрийн тойм хурлыг хийж, дүн шинжилгээг ул суурьтай явуулах.
- Дасгалжуулагчид, тамирчид болон бусад талуудын санал хүсэлтэд тулгуурлан хөтөлбөрийг илүү сайжруулж, боловсронгуй болгох.

